**“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 12-р сарын 11-ны өдөр №.01 Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх компанийг сонгон шалгаруулах, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэхь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.3дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2020 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийх, дүгнэлт гарган үйл ажиллагааны зөвлөмж гарган ажиллахтай холбоотой “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г гүйцэтгүүлэхээр үүсээд байгаа хөл хорио онцгой дэглэмийн нөхцөл байдал эрсдэлийг тооцон үзэж, 2019 оны аудитын ажлыг гүйцэтгэсэн “Аккурэйт финанс аудит” ХХК-тай гэрээ байгуулахыг ЦД 88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.

2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын ажлыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгүүлэх, шуурхай зохион байгуулж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч/Б.Болортуяа/-д даалгасугай.

3. Компанийн 2020 оны санхүүгийн тайланг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт шаардлагын дагуу хуулийн хугацаанд нь нийцүүлэн гүйцэтгэж, аудитын

тайлан дүгнэлтийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулан ажиллахыг компанийн удирдлагын багт үүрэг болгосугай.

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

........................................ / Л.Ариунболд /

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

........................................ / Г.Ганзориг /

........................................ / А.Энхгэрэл /

........................................ / П.Сайнбилэг /

........................................ / Б.Шаравсамбуу /

........................................ / Хан Гю Бунг /

........................................ / Ш.Энхтөр /

........................................ / Ч.Зоригтбаатар /

........................................ / Т.Цэнд-Аюуш /

# “МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12-р сарын 11-ны өдөр №.02 Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэхь заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 12-р сарын 11-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхий нийтээр үүсээд буй Ковид-19 –ын үеийн хорио цээрийн онцгой дэглэмийн үед амжилттай ажиллаж байгаа “Монгол Базальт” ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор 1-5 тэрбум төгрөгийн үнэт цаасны хаалттай бондыг дотоодын хөрөнгийн зах зээлд гаргах ажлыг эхлүүлэх, материал бүрдүүлэх ажлын хэсэг байгуулж ажиллахыг ЦД88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл-д зөвшөөрсүгэй.

2. Дотоодын хөрөнгийн зах зээлд компанийн үнэт цаасны хаалттай бонд гаргах ажлыг хуулийн хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, компанийн үйлдвэрлэлийн болон санхүүгийн чадавхи үйл ажиллагаанд суурилуулах ажлыг гүйцэтгүүлэхэд Үнэт цаасны “Гаүли” компанитай гэрээ байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл-д зөвшөөрсүгэй.

3. Дотоодын хөрөнгийн зах зээлд компанийн үнэт цаасны хаалттай бонд гаргах ажлыг хуулийн хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, компанийн үйлдвэрлэлийн болон санхүүгийн чадавхи үйл ажиллагаанд суурилуулах ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал/А.Энхгэрэл/-, ажлын хэсэгт даалгасугай.

4. Дээрхи үйл ажиллагаатай холбоотой ажлын гүйцэтгэлд Монгол улсын компанийн тухай хууль, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

............................................................. / Л.Ариунболд /

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

............................................................. / Г.Ганзориг /

............................................................. / А.Энхгэрэл /

............................................................. / П.Сайнбилэг /

............................................................. / Б.Шаравсамбуу /

............................................................. / Хан Гю Бунг /

............................................................. / Ш.Энхтөр /

............................................................. / Ч.Зоригтбаатар /

............................................................. / Т.Цэнд-Аюуш /

BASALTWOOL®
МОНГОЛБАЗАЛЬТ ХК

**“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 12-р сарын 11-ны өдөр №.03 Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.6 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12-р сарын 11-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн үнэт цаасны хаалттай бонд гаргах үйл ажиллагааны материал боловсруулах, гүйцэтгэхэд хөрөнгийн үнэлгээний болон хуулийн компанийг сонгон ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох тухай харилцан ашигтай хамтран ажиллах гэрээ байгуулахыг ЦД88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулсан компаниудтай хамтран ажиллах гэрээ хэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах, компанийг төлөөлөх эрхийн зөвшөөрлийг ЦД 88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд зөвшөөрсүгэй.

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК МАТЕРИАЛЫН ДУЛААН ТУСГААРЛАГЧ 5112443 1117245378

........................................ / Л.Ариунболд /

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

........................................ / Г.Ганзориг /

........................................ / А.Энхгэрэл /

........................................ / П.Сайнбилэг /

........................................ / Б.Шаравсамбуу /

........................................ / Хан Гю Бунг /

........................................ / Ш.Энхтөр /

........................................ / Ч.Зоригтбаатар /

........................................ / Т.Цэнд-Аюуш /

**“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 12-р сарын 11-ны өдөр №.04 Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.9.3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12-р сарын 11-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2020 онд дэлхий нийтэд үүсээд байгаа Ковид-19 цар тахлын улмаас компанийн үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагаанд үүссэн нөхцөл байдлыг үндэслэн компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжихэд зориулан ХААН банкнаас 2019 оны 12-р сард авсан “Монсефф” төслийн урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийн хугацааг 12 сараар хойшлуулах зөвшөөрлийг ЦД88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд зөвшөөрсүгэй.

2. “Монсефф” төслийн урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг 12 сараар хойшлуулах хүсэлтээ ХААН банк-д албан тоотоор илгээж хэрэгжүүлж

ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, Ерөнхий нягтлан бодогч /Б.Болортуяа/ нарт даалгасугай.

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

................................................ / Л.Ариунболд /

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

................................................ / Г.Ганзориг /

................................................ / А.Энхгэрэл /

................................................ / П.Сайнбилэг /

................................................ / Б.Шаравсамбуу /

................................................ / Хан Гю Бунг /

................................................ / Ш.Энхтөр /

................................................ / Ч.Зоригтбаатар /

................................................ / Т.Цэнд-Аюуш /

**“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 12-р сарын 11-ны өдөр №.05 Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.9.3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12-р сарын 11-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2020 онд дэлхий нийтэд үүсээд байгаа Ковид-19 цар тахал, УОК-оос авч хэрэгжүүлж байгаа өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд ажиллах хөл хорионы дэглэмийн улмаас компанийн үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагаанд үүссэн нөхцөл байдал, эдийн засгийн эрсдэлийг тооцон үзэж, үйлдвэрлэлийн тасралтгүй байнгын бэлэн байдлыг хангах үүднээс шугамын зээлийн эх үүсвэрийг 500,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх зөвшөөрлийг ЦД 88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд олгосугай.

2. Үйлдвэрлэлийн тасралтгүй байнгын бэлэн байдлыг хангах үүднээс Монгол улсын Засгийн газар, УОК-ийн гаргасан шийдвэрийг үндэслэн шугамын зээлийн төлөлтийг 12 сараар хойшлуулах хүсэлтээ ХААН банк-д гарган хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, Ерөнхий нягтлан бодогч /Б.Болортуяа/ нарт даалгасугай.

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

........................................ / Л.Ариунболд /

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

........................................ / Г.Ганзориг /

........................................ / А.Энхгэрэл /

........................................ / П.Сайнбилэг /

........................................ / Б.Шаравсамбуу /

........................................ / Хан Гю Бунг /

........................................ / Ш.Энхтөр /

........................................ / Ч.Зоригтбаатар /

........................................ / Т.Цэнд-Аюуш /